



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига,
албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх
талаар авч хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдаас ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэргийг эрс бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг сайжруулах, Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ сүүлийн жилүүдэд тогтмол буурахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, төрийн хүнд суртлыг арилгаж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2.Авлигатай тэмцэх, авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан Ажлын хэсэгт үүрэг болгосугай:

3.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах, Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна” гэж тус тус хуульчилсны дагуу төрийн өндөр албан тушаалтан болон уг албан тушаалыг хашиж байсан этгээдүүд үндэслэлгүй хөрөнгөжсөн эсэх асуудлыг хянан шалгах, шаардлагатай тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг цагдаагийн байгууллагатай хамтран явуулах санал, хүсэлтийг Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорт 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлэх;

3.2.хуульд зааснаас бусад бизнес эрхлэгчдэд хүнд суртал, саад, дарамт учруулж байгаа бүх төрлийн зөвшөөрөл (бүртгэл, гэрээ, гэрчилгээ, дүгнэлт, лавлагаа, санал, дүгнэлт авах г.м), дүрэм, журам, заавар, захиргааны актуудыг хүчингүй болгох

санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

3.3.авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр багц хуулийн төсөл боловсруулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

3.4.төрийн үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилтын хүрээнд албаны нууцыг хүчингүй болгох чиглэлээр Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

3.5.авлигын эсрэг төсөөллийн индексийн оноо, эрэмбийг тодорхойлоход нөлөөлдөг судалгааны байгууллага, судлаач, шинжээч болон хөрөнгө оруулагчдад төрөөс авлигын эсрэг авч хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа, ололт, амжилтын талаарх мэдээ, мэдээллийг “нэг цонх”-ны зарчмыг баримтлан хүргэх ажлыг зохион байгуулах;

3.6.ардчилал, хүний эрх, засаглал, эдийн засаг, бизнесийн чиглэлээр судалгаа, мэдээлэл бэлтгэдэг агентлагууд, “Ам Чам”, “ЕвроЧамбер Монголиа” зэрэг худалдааны танхим, гадаад, дотоодын бодлогын судалгаа хийдэг эрдэмтэн судлаач, шинжээч, бизнес эрхлэгч, иргэний нийгмийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хамтран ажиллах;

3.7.“Транспэрэнси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас удаа дараа зөвлөмж болгосон шүгэл үлээгчийн эрх зүйн байдал болон гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх хуулийн төслүүдийг боловсруулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

3.8.хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдэд хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал болон ёс зүйн алдаа гаргасан, эрх ашгийг нь хохироосон, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдсон төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад хариуцлага тооцох арга хэмжээг зохион байгуулах;

3.9.олон нийтэд ил тод болгохоор хуульд заасан мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, тогтмол шинэчилж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

3.10.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг ашиглан шамшигдуулсан нийтийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хууль бусаар олсон хөрөнгийг хураах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

4.Катар Улсын Доха хотноо 2025 оны 12 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулагдах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцын Оролцогч талуудын Бага хурлын 11 дэх чуулганаар Монгол Улсын санаачлах “Сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намууд болон сонгуулийн компанит ажлуудын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх тухай” тогтоолын төслийг хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Гадаад

харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар нарт даалгасугай.

5.Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.


6.Монгол Улсын талаарх авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбийг сайжруулах чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ажлын явц, дүнг сар бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод даалгасугай.

7.Нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх зорилтын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг арга хэмжээг бүх талаар дэмжиж, хяналт, хариуцлагаа сайжруулан, авлига, ашиг сонирхлын эсрэг “Шүгэл үлээгч”, “Шударга ёсны дуу хоолой” болж ажиллахыг нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчдэд уриалсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга.
- Дэд дарга: -Авлигатай тэмцэх газрын дэд дарга (зөвшилцсөнөөр).
- Гишүүд: -Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх.

Нарийн бичгийн
дарга:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга;

-Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр).

---o0o---



Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар
сарын 13-ны өдрийн 64 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ, АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН,
НӨХЦӨЛИЙГ АРИЛГАХ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025 онд)

Д/д	“Транспэрэнси Интернэшнл” ОУТБ-аас өгсөн зөвлөмж (2019-2024 он)	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг.Мэдээллэйн ил тод байдал, иргэний мэдэх эрхийг хангах				
1.1.	Төрийн анхан шатны мэдээлэл хомс, нээлттэй, ил тод биш	Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах (Албаны нууцтай холбоотой зохицуулалтыг хүчингүй болгох)	2025.09.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ЗГХЭГ, Тагнуулын ерөнхий газар
1.2.	Иргэдийн мэдэх эрхийг хангах	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хийсэн үнэлгээний нэгдсэн тайланг танилцуулж, холбогдох арга хэмжээ авах Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүнг боловсронгуй болгох санал танилцуулах	2025.09.03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах 2025.09.03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ХЗДХЯ Сангийн яам
1.3.	Иргэдийн мэдэх эрхийг хангах асуудал доголдолтой, төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо дутагдалтай	Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл боловсруулах шатанд E-Mongolia цахим системээр дамжуулан иргэд, аж ахуйн нэгжээс санал авах, иргэдийн оролцоотой улсын төсвийг төлөвлөх ажлыг зохион байгуулж, цаашид иргэдийн саналд үндэслэсэн төсвийн төсөл боловсруулах суурь зарчмыг хэвшүүлэн хэрэгжүүлэх Засгийн газраас өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд иргэд, олон нийтийн саналыг заавал авах, нээлттэй	2025 оноос эхэлж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Сангийн яам Бүх яамд

		хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулахад анхаарах, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хууль тогтоомжийн төслийг УИХ-д яаралтай горимоор өргөн мэдүүлэхгүй байх		
Хоёр.Төрийн албан дахь авлигыг бууруулах				
2.1.	Авлигын хэрэгт холбогдсон төрийн өндөр албан тушаалтны хэрэг шийдэгдэхгүй, шударга ёсны шүүхээс ангид байх үзэгдэл давтагдаж байна	Төрийн өндөр албан тушаалтан болон уг албан тушаалыг хашиж байсан этгээдүүд үндэслэлгүй хөрөнгөжсөн эсэх асуудлыг хянан шалгах, шаардлагатай тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг цагдаагийн байгууллагатай хамтран явуулах санал, хүсэлтийг Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорт гаргах санал бэлтгэж, танилцуулж, шийдвэрлүүлэх Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, үндэслэлгүй хөрөнгөжсөн, нийтийн өмчийг ашиглан шамшигдуулсан нийтийн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, хууль бусаар олсон хөрөнгийг хураах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, танилцуулж, шийдвэрлүүлэх	2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ХЗДХЯ
		Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр багц хуулийн төсөл боловсруулж, танилцуулж, шийдвэрлүүлэх	2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ХЗДХЯ
2.2.	Төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, мэдрэмж, дутмаг тул чадавхжуулах, мэргэшүүлэх	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давшан сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, хүний эрхийн мэдлэг, мэдрэмжийг дээшлүүлэх чиглэлээр агуулгыг баяжуулах, сургагч багшийг бэлтгэх, шаардлагатай бол хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, танилцуулж, шийдвэрлүүлэх	2025.10.01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ЗГХЭГ, Удирдлагын академи
2.3.	Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг ил тод болгох	Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэхтэй холбоотой асуудлыг тусгайлан зохицуулсан хуулийн төсөл боловсруулах	2025 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ЗГХЭГ, Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг
		Төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүн, тайланг цахим хуудсанд байршуулах тухай Засгийн газрын тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	2025 оноос эхэлж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	ЗГХЭГ

2.4.	Төрийн албан хаагчийн орлогыг ХАСХОМ-оор хянаж байгаа нь олон улсын зарчимд нийцэхгүй байна. Зарлагыг мөн хянах	Төрийн албан хаагчийн орлого, зарлагыг олон улсын жишигт нийцүүлэн хянах боломжийн талаар санал бэлтгэж, танилцуулах	2025.09.10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ХЗДХЯ, Сангийн яам, АТГ
2.5.	Төрийн байгууллагын зөвлөх үйлчилгээний үр дүнд суурилсан үнэлгээ хийх	Төрийн байгууллагуудын хийж байгаа зөвлөх үйлчилгээний гэрээнд дүнд шинжилгээ хийж, дүнг танилцуулах, цаашид тодорхой хувиар бууруулах арга хэмжээ авах	2025.09.10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	Сангийн яам
Гурав.Бизнесийн орчин дахь авлигыг бууруулах				
3.1.	Тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх	Зөвшөөрлийн хуульд зааснаас бусад аливаа төрлийн зөвшөөрөл (бүртгэл, гэрээ, гэрчилгээ, дүгнэлт, лавлагаа, санал ...гэх мэт)-ийг хүчингүй болгох санал боловсруулах Хуулиар эрх олгогдоогүй дүрэм, журам болон бусад захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох Зөвшөөрлийг бүрэн цахимжуулах	2025.10.01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	ЗГХЭГ, Бүх яамд
3.2.	Уул уурхайн засаглалыг сайжруулах, эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх. Үндэсний баялгийн сангийн эрх зүй тодорхойгүй, баялгийн үр өгөөж иргэдэд хүртээмжгүй	Байгалийн баялгийн орлогоос бүрдэх сангуудын хуримтлал, зарцуулалтад дүн шинжилгээ хийж, олон нийтэд ил тод болгох ажлыг боловсронгуй болгох (Ирээдүйн өв сэн, Хуримтлалын сангийн орлого төвлөрүүлэлт болон иргэдэд хуваарилах нэрийн дансны мэдээллийг E-Mongolia цахим системээр дамжуулан харах боломжтой)	2025 оноос эхэлж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Сангийн яам, ЭЗХЯ, ГБХНХЯ
3.3.	Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах	“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх	2025.09.10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, УИХ-ын 2025 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх	ЗГХЭГ, ТӨБЗГ

		“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах	2025 оноос эхэлж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Сангийн яам, ТӨБЗГ
3.4.	Татварын тооцооллыг тодорхой болгох	Татварын маргаан таслах зөвлөл болон бусад захиргааны байгууллагын дэргэдэх маргаан шийдвэрлэх зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, 2025 оны улсын төсвийн тухай хуулийн хүрээнд боловсруулсан татварыг боловсронгуй болгох хуулийн зохицуулалтыг иргэдэд хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах	2025 оноос эхэлж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Сангийн яам, Татварын ерөнхий газар
3.5.	Бизнесийн орчны дарамт шахалтыг бууруулах, тогтвортой байдлыг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Дэд бүтцийг сайжруулах, бизнесийн салбарын гомдлыг зохистой шийдвэрлэхгүй, зохицуулагч байгууллагуудын хяналт, хариуцлага тааруу байна	Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төслийг боловсруулан танилцуулж шийдвэрлүүлэх Бизнес эрхлэгчдийн гомдол, санал, хүсэлтийг Засгийн газрын түвшинд шуурхай шийдвэрлэдэг эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал бэлтгэн танилцуулах	2025.10.15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаан танилцуулах	ЭЗХЯ
3.6.	Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах, төрөөс хөрөнгө оруулалтын баталгааг бий болгох эрх зүйн орчин дутмаг байна	Хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх	2025.10.15-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаан танилцуулах	ЭЗХЯ, Шадар сайд (гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн), Хөрөнгө оруулалт, худалдааны газар
3.7.	Худалдан авалт, гэрээний найдвартай, ил тод байдлыг хангах	-Төсөл, тендер сонгон шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож, гэрээний хяналт, хариуцлагыг сайжруулах; -Шууд худалдан авалт зохион байгуулах журам, аргачлал, шалгуурыг тодорхой болгох; -Худалдан авах ажиллагааны гэрээний жишиг баримт бичгийг шинэчлэн батлах.	2025 оноос эхэлж цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	ЗГХЭГ, Сангийн яам, ТХААГ

Дөрөв.Шинээр батлах хууль				
4.1.	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль	Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах, батлуулах	2025.09.10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, УИХ-ын 2025 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх	ХЗДХЯ
4.2.	Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг батлуулах		
4.3.	Худалдан авах ажиллагааны тухай хууль	Худалдан авах ажиллагааны тухай хуулийг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулах, батлуулах	2025 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх	ЭЗХЯ, Сангийн яам, ТХААГ
Тав.Засгийн газрын бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх				
5.1.	Авлигын эсрэг төсөөллийн индексийн оноо, эрэмбийг тодорхойлоход нөлөөлдөг судалгааны байгууллага, судлаач, шинжээч болон хөрөнгө оруулагчдад авлигын чиглэлээр хэрэгжүүлж байгаа Монгол Улсын ололт, амжилтын талаарх мэдээ, мэдээлэл болон Засгийн газрын бодлого, арга хэмжээг хүргэхдээ "нэг цонх"-ны зарчмыг баримтлан ажиллах	Яамд, Ерөнхий сайдын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар холбогдох байгууллагаас санал авч, нэгдсэн төлөвлөгөө гаргаж ажиллах	ЗГХЭГ, ГХЯ	
5.2.	Ардчилал, хүний эрх, засаглал, эдийн засаг, бизнесийн чиглэлээр судалгаа, мэдээлэл бэлтгэдэг агентлагууд, "Ам Чам", "ЕвроЧамбер Монголиа" зэрэг худалдааны танхимуудтай хамтран ажиллах, олон улсын хурал, зөвлөгөөнд оролцдог гадаад, дотоодын бодлогын судалгаа хийдэг эрдэмтэн судлаач, шинжээч, бизнес эрхлэгч, иргэний нийгмийн байгууллагыг мэдээллээр хангах, хамтран ажиллах			
5.3.	Улс төр, нийгэм, эдийн засгийн чиглэлээр судалгаа хийдэг судалгааны хүрээлэн, судлаач, шинжээчид болон сэтгүүлчидтэй авлигын индексийн сэдвээр уулзалт зохион байгуулж, холбогдох мэдээллийг өгөх		2025 оны 9-11 дүгээр сард багтаан зохион байгуулах	ХЗДХЯ, ЭЗХЯ, АТГ
Зургаа.Бусад				
6.1.	Өмгөөлөгч, судлаач, аналистуудыг авлигын асуудлаар мэргэшүүлэх	Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн агуулгад авлигын асуудлыг оруулах талаар хамтарч ажиллах	2025 оны 9 дүгээр сард багтаан зохион байгуулах	ХЗДХЯ, АТГ
6.2.	Монгол Улсын авлигын	Авлигын төсөөллийн индексийн судалгааны арга зүй,	сар бүр	ЗГХЭГ,

	төсөөллийн үнэлгээ, сайжруулах	индексийн эрэмбийг сайжруулах	асуумжуудад дүн шинжилгээ хийж, дүнд үндэслэн Монгол Улсын үнэлгээ, эрэмбийг сайжруулах арга хэмжээ, төлөвлөн хэрэгжүүлэх		АТГ
6.3.	Дэлхийн Шударга Төсөл (World Justice Project)-тэй санамж бичиг байгуулах	Дэлхийн 142 улсад Хуулийн засаглалын индексийн үнэлгээг жил бүр гаргадаг тус олон улсын байгууллагатай санамж бичиг байгуулах, цаашид хамтран ажиллах	2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх		ЗГХЭГ
6.4	Катар Улсын Доха хотноо 2025 оны 12 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд болох НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын Оролцогч талуудын бага хурлын 11 дэх чуулганд оролцох бэлтгэл ажлыг хангах	Тус чуулганаар хэлэлцүүлэх “Сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намууд болон сонгуулийн компаниг ажлуудын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх тухай” тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хурал, зөвлөгөөнд оролцох	2025.12.03-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх		ЗГХЭГ, ГХЯ, ХЗДХЯ

---o0o---